


“Монгол дахь манай хүн: Чингийн дараах Монгол дахь Британийн эзэнт гүрний төлөөлөгч Чарльз Бинстийд” баримтын эмхэтгэл



Монгол Улс, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны түүхт жаран жилийн ойн хүрээнд зохион байгуулахаар төлөвлөсөн олон ажлын нэг болох Британийн судлаач Сью Бөрнийн “Монгол дахь манай хүн: Чингийн дараах Монгол дахь Британийн эзэнт гүрний төлөөлөгч Чарльз Бинстийд” баримтын эмхэтгэл хэвлэгдэн гарлаа.

Өнөөг хүртэл эрдэм шинжилгээний эргэлтэд хараахан оруулж амжаагүй, судлаачдын дунд “Монгол судлаачийн дайтай дэслэгч Ж.Ч.Бинстийд” хэмээн үнэлэгдсэн нэгэн жуулчин судлаач эрхмийн бичиж тэмдэглэн үлдээсэн XX зууны эхэн үеийн Монголын түүхэнд холбогдох ховор баримтуудыг уг эмхэтгэлээс олж үзэх болно.

XX зууны эхээр Монгол орноор жуулчилсан жуулчдын дотроос тухайн үеийн Монгол орон, монголчуудын талаар түүхийн үнэ цэнтэй бичгийн өв үлдээсэн хүмүүсийн тоонд дэслэгч Ж.Ч.Бинстийд зүй ёсоор тооцогдоно.

Тэрбээр төрөлхийн хэлний авьяастай, франц, орос, хятад хэлийг чадамгай эзэмшсэн, урьд таньж мэдэгдээгүй газар орноор аялан жуулчлах дур сонирхолтой нэгэн байсан бөгөөд өөрийн аялал, жуулчлалынхаа явцад олж авсан мэдлэг, цуглуулсан хэрэглэгдэхүүн, бичсэн өгүүллээрээ олонд танигдаж, Английн Газар зүйн нийгэмлэг, Азийн нийгэмлэг, Хятадын нийгэмлэгийн гишүүн болсон хүн байв.

Ж.Ч.Бинстийд 1912 он болон 1913 оны 8-9 сард Хиагт, Барга, Хайлаар, Мүгдэн, Сэцэн хан аймгийн нутгаар дамжин Нийслэл Хүрээнд ирж байжээ.

Ж.Ч.Бинстийдийн Монгол орноор жуулчилсан он жилүүд нь Монгол Улс тусгаар тогтнолоо сэргээн тунхаглаад төдий л удаагүй, улс төрийн үйл явдлаар нэн баялаг цаг үе байлаа.

Ж.Ч.Бинстийд Монголд хийсэн аяллынхаа явцад Монгол орны газар зүй, улс төр, эдийн засаг, улс төрийн байдал, сүм хийд, монголчуудын санал бодлыг судлан тэмдэглэж, аяллынхаа талаар дэлгэрэнгүй тайлан бичиж, Бээжин дэх Их Британийн

төлөөлөгчийн газарт өгдөг байв. Монгол Улс гадаад харилцаагаа өргөтгөхийг идэвхийлэн оролдож байсан түүхэн цаг үед Нийслэл Хүрээнд хүрэлцэн ирж, Монгол орны улс төрийн нөхцөл байдалтай биечлэн танилцаж, Монголын нөлөө бүхий улс төрчидтэй харилцан, уулзаж ярилцаж байсан тул Ж.Ч.Бинстийдийн тайлан, тэмдэглэлд тухайн үеийн Монголын улс төрийн хүрээнийхний байр суурийн талаар сонирхолтой мэдээллүүд бий.

Ж.Ч.Бинстийд цуглуулсан хэрэглэгдэхүүнээ боловсруулж, хэвлэн нийтэлж нийтэд хүргэх талаар тодорхой ажил хийж байв. 1914 оны 10 сард “Халхын сүм хийдийн ахуй байдал” гэдэг өгүүлэл бичиж Азийн нийгэмлэгийн сэтгүүлд хэвлүүлснээс гадна амьдралынхаа сүүлийн хоёр жилд Монголын тухай

хэд хэдэн өгүүлэл бичсэний зарим нь нас нөгчсөнөөс нь хойш хэвлэгдсэн байна. 1915 онд авьяаслаг жуулчин судлаач Ж.Ч.Бинстийд дайны талбарт цэл залуу гуч гаруйхан насандаа харамсалтайгаар нас барснаар түүний жуулчлал, судалгаа шинжилгээний ажил тасалджээ.

Толилуулан буй баримтын эмхэтгэлд Ж.Ч.Бинстийдийн 1912-1913 онд бичсэн тайлан, замын тэмдэглэл, гэрэл зургийг хэвлэн нийтэлж байна. Эдгээр баримтууд нь тухайн үеийн Монгол орон, монголчуудын талаарх шинэ мэдээлэл өгч, Монгол орноор жуулчилсан гадны жуулчдын тэр цагийн бодит ажиглалт, үнэлэмжтэй танилцах бололцоо олгож буйгаараа судалгааны зохих ач холбогдолтой юм.

Мэдээг бэлтгэсэн: Т.Анударь